



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРОО

20
24 он



НЭГДСЭН ТАЙЛАН

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГО**



УЛААНБААТАР ХОТ
2025



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
УЛСЫН ХОРОО

БИЕИЙН ТАМИР СПОРТЫН УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГЫН НЭГДСЭН ТАЙЛАН 2024

УЛААНБААТАР ХОТ
2025

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АЗБЗ	Арга зүйн байнгын зөвлөл
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БТС	Биеийн тамир спорт
БТСГ	Биеийн тамир спортын газар
ГМС	Газар зүйн мэдээллийн систем
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ИДС	Их дээд сургууль
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
СЦЗК	Спорт цогцолбор болон бэлтгэлийн зориулалттай заал, клуб
ТЗБ	Төрийн захиргааны байгууллага
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХААНБ	Хувийн аж ахуй нэгж байгууллага

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсад биеийн тамир, спортын салбар үүсэж хөгжсөн цаг хугацаанд Биеийн тамир спортын улсын хорооноос Биеийн тамир спортын улсын үзлэг тооллогыг 2 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.

Монгол Улсын Биеийн тамир спортын тухай хууль шинэчлэгдэн батлагдаж шинэ эрх зүйн орчин үйлчилж, нийгмийн хөгжил, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн салбарын бодлого, хөтөлбөрийг боловсруулах, цаашдын төлөвлөлтийг хийхэд энэхүү үзлэг тооллогын үр дүн чухал ач холбогдолтой юм.

Салбарын статистикийн суурь мэдээлэл болоод биеийн тамир, спортын чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагын мэдээллийг бүрдүүлснээр нийтийн биеийн тамирын үйлчилгээг боловсронгуй болгох, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилтын орчныг судлах, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой болно. Түүнчлэн уг тооллогоор биеийн тамир, спортын барилга байгууламжийн байршлын мэдээллийн цахим сан үүсгэх боломж бүрдэх юм.

ТАЛАРХАЛ



Биеийн тамир спортын улсын хороо нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд салбарын хөгжлийн чиг хандлага, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үрнөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын чадвар, боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, спортоор тогтмол хичээллэдэг иргэнийг төрүүлэн гаргах эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Биеийн тамир, спортын ажил үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэн бүрд ил тод, нээлттэй, түргэн шуурхай хүргэхэд салбарын хэмжээнд цахим үйлчилгээг нэвтрүүлж, үндэсний хэмжээнд биеийн тамир спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэн, төрийн зарим үйлчилгээг дижитал шилжилтийн хүрээнд хялбар, ухаалаг болгох хүрээнд энэхүү үзлэг тооллогын зохион байгууллаа. Үзлэг тооллогын мэдээлэл цуглуулах, тулгаж нягтлах, боловсруулалт хийх цахим программыг шинээр боловсруулан энэ удаагийн үзлэг тооллогод ашигласан бөгөөд тус программын хөгжүүлэлт хийгдэж захиргааны статистикийг бүрэн цахимжуулах боломжтой болж байна. Энэ нь биеийн тамир, спортын мэдээллийн цахим сангийн суурь бааз болох юм.

Биеийн тамир, спортын салбар анх удаа орон даяар спортын клубыг бүртгэн тоолж байгаа нь биеийн тамир, спортын салбарт шинэ эрх зүйн орчин бүрдэж, хөгжлийн шинэ бодлого хөтөлбөрийг боловсруулж байгаа цаг үетэй давхцаж байгаагаараа нь онцлогтой байлаа.

Биеийн тамир спортын салбарын энэхүү үзлэг тооллогыг орон даяар зохион байгуулахад удирдлагаар хангаж амжилттай ажилласан Биеийн тамир спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл, мэргэжилтэн Б.Ганзориг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ахлах мэргэжилтэн С.Мөнх-Эрдэнэ болон тооллогын ажлыг орон даяар зохион байгуулан ажилласан “Орон нутгийн хөгжлийн бодлого судлалын төв”, “Статистик дэвшил” ТББ-ын уирдлага, судлаач, тоологч нарт гүн талархал илэрхийлье.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
УЛСЫН ХОРООНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БИЛЭГТ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	2
ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ	3
ӨМНӨХ ҮГ	4
ТАЛАРХАЛ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	9
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	10
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН НЭГ УДААГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ	12
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ	12
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ	12
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ	12
ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН НЭГЖ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЯВУУЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ	13
ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	13
ТООЛЛОГЫН ТОВ, ХУГАЦАА	14
ТООЛЛОГЫН АСУУЛГЫН МАЯГТ	14
ТООЛЛОГЫН АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ	14
ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ГАЗРЫН ЗУРАГ	14
МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ	15
 НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СПОРТЫН ЗААЛ	18
1.1. СПОРТ ЗААЛНЫ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	18
1.2. СПОРТ ЗААЛНЫ ХИЙЦИЙН МАТЕРИАЛ	28
1.3. СПОРТ ЗААЛНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ	34
 ХОЁРДУГААР БҮЛЭГ. СПОРТЫН ГАДАА ТАЛБАЙ	48
2.1 СПОРТЫН ГАДАА ТАЛБАЙН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	48
2.2 СПОРТЫН ГАДАА ТАЛБАЙН ТӨРӨЛ, НӨХЦӨЛ	53
2.3 СПОРТЫН ГАДАА ТАЛБАЙД СПОРТЫН АРГАХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ...68	
 ГУРАВДУГААР БҮЛЭГ. СПОРТЫН КЛУБ	71
3.1. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	71
3.2. СПОРТЫН КЛУБИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАЙДАЛ	74
3.2. СПОРТЫН КЛУБИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ	78
ХАВСРАЛТ	88
ХАВСРАЛТ 1. ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, ШИНЭ БҮСЭЭР	88
ХАВСРАЛТ 2. ҮР ДҮНГИЙН ХҮСНЭГТҮҮД	95
ХАВСРАЛТ 3. АСУУЛГЫН ХУУДАС	116

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Спорт заалны тоон үзүүлэлт, 2017 ба 2024 оны харьцуулсан байдлаар, аймаг, нийслэлээр	20
Хүснэгт 2. Спорт заалны үйл ажиллагааны явуулж буй хэлбэр, аймаг, нийслэлээр	21
Хүснэгт 3. Спорт заалны ангилал, аймаг, нийслэлээр	22
Хүснэгт 4. Спорт заалны үйл ажиллагааны зориулалт, үйл ажиллагааны хэлбэрээр	24
Хүснэгт 5. Спорт заалны өмчийн хэлбэр, аймаг, нийслэлээр	24
Хүснэгт 6. Спорт заалны хэмжээ аймаг, нийслэлээр	27
Хүснэгт 7. Спорт заалны цахилгааны эх үүсвэр, аймаг, нийслэлээр	28
Хүснэгт 8. Спорт заалны ханын үндсэн хийц, аймаг, нийслэлээр	30
Хүснэгт 9. Спорт заалны шалны үндсэн хийц, аймаг, нийслэлээр	32
Хүснэгт 10. Спорт заалны шалны хучилтын материал, аймаг, нийслэлээр	33
Хүснэгт 11. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал, аймаг, нийслэлээр	35
Хүснэгт 12. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал, ашиглалтад орсон оноор	35
Хүснэгт 13. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал	35
Хүснэгт 14. Спорт заалны Их засвар хийсэн он, ашиглалтад орсон оноор	36
Хүснэгт 15. Спорт заалны гэрэлтүүлэг байдал, ашиглалтад орсон оноор	36
Хүснэгт 16. Спорт заалны үзэгчийн суудалтай эсэх, суудлын тоо, аймаг, нийслэлээр	38
Хүснэгт 17. Спорт заалны багш, дасгалжуулагчийн өрөөний тоо, аймаг, нийслэлээр	39
Хүснэгт 18. Спорт заалыг түрээсэлдэг эсэх, спорт заалны өдрийн дундаж орлого, мянган төгрөгөөр, аймаг, нийслэлээр	41
Хүснэгт 19. Спорт заалны ашиглалтын тоон үзүүлэлт	42
Хүснэгт 20. Спорт заалны ажилчдын байдал, албан тушаалаар	42
Хүснэгт 21. Спорт заалны ажилчдын байдал, аймаг, нийслэл, албан тушаал, хүйсээр	43
Хүснэгт 22. Спортын гадаа талбайн тоо, аймаг, нийслэлээр, 2017 болон 2024 оноор	49
Хүснэгт 23. Спортын гадаа талбайн өмчийн хэлбэр, 2017 болон 2024 оноор	50
Хүснэгт 24. Төрийн өмчийн гадаа талбай, 2017 болон 2024 онуудаар, бүсээр, дүнд эзлэх хувиар	50
Хүснэгт 25. Спортын гадаа талбай, үйл ажиллагааны үндсэн зориулалтаар, 2017 болон 2024 онуудаар, дүнд эзлэх хувиар	51
Хүснэгт 26. Ерөнхий боловсролын сургуулийн гадаа талбай, бүсээр, дүнд эзлэх хувиар, 2017 болон 2024 оноор	52
Хүснэгт 27. Төрийн захиргааны байгууллагын гадаа талбай, бүсээр, дүнд эзлэх хувиар, 2017 болон 2024 оноор	52
Хүснэгт 28. Спортын гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, дүнд эзлэх хувиар, 2017 болон 2024 он	53
Хүснэгт 29. Нэг төрөлд ашиглах зориулалттай гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, бүсээр, 2017 болон 2024 оноор, дүнд эзлэх хувиар	54
Хүснэгт 30. Холимог төрөлд ашиглах зориулалттай гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, бүсээр, 2017 болон 2024 оноор, дүнд эзлэх хувиар	54
Хүснэгт 31. Спортын гадаа талбайн тоо, талбайн зориулалтын төрөл, бүс, аймаг, нийслэл, дүнд эзлэх хувиар	54
Хүснэгт 32. Спортын гадаа талбайн тоо, талбайн зориулалтын төрөл, аймаг, нийслэлээр, 2018-2024 он	56
Хүснэгт 33. Спортын гадаа талбайн нийт хэмжээ, талбайн зориулалтын төрөл, аймаг, нийслэлээр	57
Хүснэгт 34. Спортын гадаа талбай, засвар хийсэн он, дүнд эзлэх хувиар	59

Хүснэгт 35. Спортын гадаа талбайн тоо, ашиглалтад оруулсан он, засвар хийсэн он, улсын дүнгээр	60
Хүснэгт 36. Спортын гадаа талбайн хучилтын материал, төрлөөр, дүнд эзлэх хувиар	61
Хүснэгт 37. Биеийн тамир, спортын гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, ашиглалтын давтамж, бүс, дүнд эзлэх хувиар	62
Хүснэгт 38. Спортын гадаа талбай, үзэгчийн суудалтай эсэх, бүсээр, дүнд эзлэх хувиар..	63
Хүснэгт 39. Спортын гадаа талбайн үзэгчийн суудлын тоо	63
Хүснэгт 40. Спортын гадаа талбайн тоо, гэрэлтүүлгээр, бүсээр	63
Хүснэгт 41. Унадаг дугуйн замтай спортын гадаа талбайн тоо, замын нийт болон дундаж урт, метрээр	64
Хүснэгт 42. Алхалтын замтай спортын гадаа талбайн тоо, замын нийт болон дундаж урт, метрээр	65
Хүснэгт 43. Спортын гадаа талбайн тоо, өнгөрсөн 7 хоногт ажилласан хоногийн тоо	65
Хүснэгт 44. Спортын гадаа талбайн тоо, нэг жилд ажилласан сарын тоогоор	66
Хүснэгт 45. Спортын гадаа талбайн тоо, өдөрт ажилладаг дундаж цаг	66
Хүснэгт 46. Спортын талбайн тоо, ажиллагчтай эсэх, ажиллагчдын тоогоор	67
Хүснэгт 47. Спортын гадаа талбайн ажиллагчдын тоо, бүсээр	68
Хүснэгт 48. Спортын арга хэмжээ зохион байгуулах боломжтой гадаа талбайн тоо, спортын төрлөөр, бүсээр.....	68
Хүснэгт 49. Спортын талбайд сүүлийн 1 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулсан спорт холбоо, клубийн тоо.....	69
Хүснэгт 50. Спортын клубийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, аймаг, нийслэлээр	73
Хүснэгт 51. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, шаардлагатай бол мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх, аймаг, нийслэлээр	76
Хүснэгт 52. Спорт клубийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэхэд төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байна вэ?, аймаг, нийслэлээр.....	83
Хүснэгт 53. Байнгын ажилтны тоо, аймаг, нийслэлээр.....	84
Хүснэгт 54. 2023 оны орлогын мэдээлэл, бүсээр, сая төгрөгөөр	85
Хүснэгт 55. Спорт заалны үйл ажиллагааны зориулалт, аймаг, нийслэлээр.....	95
Хүснэгт 56. Спорт заалны ашиглалтад орсон он, аймаг, нийслэлээр	96
Хүснэгт 57. Спорт заалны халаалтын эх үүсвэр, аймаг, нийслэлээр	97
Хүснэгт 58. Спорт заалны гэрэлтүүлэг байдал, аймаг, нийслэлээр	98
Хүснэгт 59. Спорт заалны хувцас солих өрөөний байдал, аймаг, нийслэлээр.....	99
Хүснэгт 60. Спорт заалны шүршүүрийн өрөөний байдал, аймаг, нийслэлээр	100
Хүснэгт 61. Спорт заалны бие засах өрөөний байдал, аймаг, нийслэлээр	101
Хүснэгт 62. Спорт заалны ашиглалтын тоон үзүүлэлт, аймаг, нийслэлээр	102
Хүснэгт 63. Спортын гадаа талбайн тоо, үйл ажиллагааны үндсэн зориулалт, аймаг, нийслэл, дүнд эзлэх хувиар	103
Хүснэгт 64. Спортын гадаа талбайн тоо, өнгөрсөн сард ажилласан хоногийн тоо.....	104
Хүснэгт 65. Бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа спортын клуб, аймаг, нийслэлээр .	105
Хүснэгт 66. Спортын клубийн өмчийн хэлбэр, аймаг, нийслэлээр	106
Хүснэгт 67. Спортын клубийн үйл ажиллагаа явуулж буй спортын төрөл, бүсээр	107
Хүснэгт 68. Спортын клубийн үйл ажиллагааны мэдээлэл, аймаг, нийслэлээр.....	108
Хүснэгт 69. Спортын клубийн үйл ажиллагаа үзүүлэх орчны нийтлэг стандартын ишлэл, хэрэгжилтийн шалгуурыг хангаж байгаа эсэх, аймаг, нийслэлээр	109
Хүснэгт 70. Спортын клубийн үйл ажиллагаанд мөрдлөг болгох эрх зүйн бичиг баримт, стандарт, бусад шалгуур хангаж байгаа эсэх, аймаг, нийслэлээр	110
Хүснэгт 71. Спортын клубийн үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд, аймаг, нийслэлээр ..	111
Хүснэгт 72. Өнгөрсөн 2023 онд холбоо, клубээс зохион байгуулсан тэмцээний тоо, оролцсон тамирчдын тоо, аймаг, нийслэлээр	112

Хүснэгт 73. Спортын клубийн 2023 онд холбоо, клубээр нийт үйлчлүүлсэн хүмүүсийн тоо, аймаг, нийслэлээр	113
Хүснэгт 74. Спортын клубийн үйл ажиллагааны зарим үзүүлэлт, аймаг, нийслэлээр	114
Хүснэгт 75. Спортын клубийн ажиллагчдын тоо, албан тушаал болон хүйсээр, аймаг, нийслэлээр	115

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Спорт заалны тоон үзүүлэлт, бүсээр	19
Зураг 2. Спорт заалны тоон үзүүлэлт, аймаг, нийслэлээр	19
Зураг 3. Спорт заалны тоон үзүүлэлт, 2017 ба 2024 оны харьцуулсан байдлаар	20
Зураг 4. Улсын хэмжээнд байгаа нийт спорт заалны тоо	21
Зураг 5. Спорт заалны үйл ажиллагааны явуулж буй улирал, аймаг, нийслэлээр	23
Зураг 6. Спорт заалны үйл ажиллагааны зориулалт	23
Зураг 7. Спорт заалны хэмжээ, бүс, нийслэлээр	26
Зураг 8. Нэг хүнд ноогдох заалны хэмжээ	27
Зураг 9. Спорт заалны цахилгааны эх үүсвэр	28
Зураг 10. Спорт заалны халаалтын эх үүсвэр	29
Зураг 11. Спорт заалны ханын үндсэн хийц	30
Зураг 12. Спорт заалны шалны үндсэн хийц	31
Зураг 13. Спорт заалны шалны хучилтын материал	33
Зураг 14. Спорт заалны гэрэлтүүлгийн байдал	36
Зураг 15. Спорт заалны үзэгчийн суудалтай эсэх, суудлын тоо	37
Зураг 16. Спорт заалны багш, дасгалжуулагчийн өрөөний байдал	38
Зураг 17. Спорт заалны хувцас солих өрөөний байдал	39
Зураг 18. Сүүлийн нэг жилийн хугацаанд зохиогдсон спортын үйл ажиллагааны тоо	44
Зураг 19. Спортын гадаа талбайн тоо, аймаг, нийслэлээр	48
Зураг 20. Спортын гадаа талбай, бүсээр, дүнд эзлэх хувиар	52
Зураг 21. Спортын гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, дүнд эзлэх хувиар	53
Зураг 22. Спортын гадаа талбай, талбайн зориулалтын төрөл, бүсээр, дүнд эзлэх хувиар	53
Зураг 23. Нэг хүнд ногдох спортын гадаа талбайн хэмжээ, аймаг, нийслэлээр, м ²	58
Зураг 24. Спортын гадаа талбай, ашиглалтын давтамж, улирлаа, дүнд эзлэх хувиар	62
Зураг 25. Спортын гадаа талбайн тоо, унадаг дугуй болон явган алхалтын замаар, бүсээр	64
Зураг 26. Спортын гадаа талбайн нэг өдрийн түрээсийн дундаж орлого, бүсээр	65
Зураг 27. Спортын гадаа талбайгаар нэг өдөрт дунджаар үйлчлүүлдэг хүний тоо	67
Зураг 28. Спортын гадаа талбайгаар нэг удаа үйлчлүүлэхэд зарцуулдаг хугацаа, минутаар	67
Зураг 29. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй спортын клубийн тоо, аймаг, нийслэлээр	71

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

График 1. Спорт заалны тоон үзүүлэлт	18
График 2. Спорт заалны ангилал.....	22
График 3. Спорт заалны өмчийн хэлбэр	24
График 4. Спорт заалны өмчийн хэлбэр, зориулалтаар	25
График 5. Спорт заалны ашиглалтад орсон он	26
График 6. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал.....	34
График 7. Спорт заалны үзэгчийн суудлын байдал, ашиглалтад орсон оноор.....	37
График 8. Спорт заалны ариун цэврийн өрөөний байдал	40
График 9. Спорт заалны ариун цэврийн өрөөний хүйсээр ялгагдсан байдал, өрөөний тоогоор.....	40
График 10. Спорт заалыг түрээсэлдэг эсэх	41
График 11. Спорт заалны ажилчдын байдал	42
График 12. Спорт заалны хичээллүүлдэг спортын төрөл	45
График 13. Спортын гадаа талбайн тоо	48
График 14. Спортын гадаа талбай, өмчийн хэлбэр, дүнд эзлэх хувиар	49
График 15. Төрийн өмчийн гадаа талбай, дүнд эзлэх хувиар	50
График 16. Спортын гадаа талбай, үйл ажиллагааны үндсэн зориулалт, дүнд эзлэх хувиар	51
График 17. Спортын гадаа талбай, ашиглалтад орсон он, дүнд эзлэх хувиар	55
График 18. Спортын гадаа талбайн тоо, талбайн зориулалтын төрөл, ашиглалтад орсон оноор.....	55
График 19. Ашиглалтад орсон спортын гадаа талбай, бүс, нийслэл, дүнд эзлэх хувиар, 2024 он.....	56
График 20. Спортын гадаа талбай, талбайн хэмжээ (m^2), дүнд эзлэх хувиар	57
График 21. Нэг хүнд ногдох спортын гадаа талбайн хэмжээ, талбайн зориулалтын төрөл, бүс, нийслэлээр, m^2	58
График 22. Спортын гадаа талбайн тоо, талбайд засвар хийсэн эсэх, дүнд эзлэх хувиар .	59
График 23. Спортын гадаа талбай, хүрээлсэн хашааны төрөл, дүнд эзлэх хувиар	60
График 24. Спортын гадаа талбай, хүрээлсэн хашааны төрөл, бүс, дүнд эзлэх хувиар.....	61
График 25. Спортын гадаа талбайн хучилтын материал, дүнд эзлэх хувиар	61
График 26. Спортын гадаа талбай, ашиглалтын давтамж, дүнд эзлэх хувиар	62
График 27. Спортын гадаа талбай, үзэгчийн суудалтай эсэх, дүнд эзлэх хувиар	63
График 28. Спортын гадаа талбайн гэрэлтүүлэг, дүнд эзлэх хувиар	63
График 29. Спортын талбай, түрээсэлдэг эсэх, бүсээр, дүнд эзлэх хувиар.....	65
График 30. Спортын талбайн тоо, ажиллагчтай эсэх, дүнд эзлэх хувиар	67
График 31. Спортын арга хэмжээ зохион байгуулах боломжтой гадаа талбайн тоо, спортын төрлөөр	68
График 32. Биеийн тамир спортын клубийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн он цагийн дараалал	71
График 33. Бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, бүсээр.....	72
График 34. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, бүсээр	72
График 35. Өмчийн хэлбэр, нийт түүврийн хувьд.....	74
График 36. Спортын клубын үйл ажиллагаа явуулж буй спортын төрөл.....	75
График 37. Магадлан итгэмжлэгдсэн эсэх, бүсээр	75
График 38. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, шаардлагатай бол мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэх, бүсээр.....	76
График 39. Байгууллагын батлагдсан дүрэм, журам, бүтэц орон тоо, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй эсэх, бүсээр	77

График 40. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитаар баталгаажсан эсэх, бүсээр....	77
График 41. Нийгмийн даатгалын шимтгэл төлдөг эсэх, бүсээр.....	78
График 42. Спортын клубийн үйл ажиллагаа үзүүлэх орчны нийтлэг стандартын ишлэл, хэрэгжилтийн шалгуурыг хангаж байгаа эсэх, бүсээр.....	78
График 43. Үйл ажиллагаанд мөрдлөг болгох эрх зүйн бичиг баримт, стандарт, бусад шалгуур хангаж байгаа эсэх, бүсээр.....	79
График 44. Биеийн тамирын багш, спортын дасгалжуулагч. MNS 5323-12:2004 стандартыг хангаж ажилладаг эсэх, бүсээр.....	79
График 45. Эрүүл мэндийг хамгаалах технологи. Эмчилгээ үйлчилгээний түгээмэл үйлдлүүд MNS 4621:1998 стандартыг хангаж ажилладаг эсэх, бүсээр.....	79
График 46. Туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, зэрэг ахиулах, дадлагажуулах сургалтад хамруулах байдал хэрэгждэг эсэх, бүсээр	80
График 47. Ажиллагчдын эрүүл мэнд, хувийн хэргийн бүрдүүлэлт, дэлгэрэнгүй судалгаатай эсэх, бүсээр	80
График 48. Батлагдсан үйлчилгээний төлбөр хураамжийн тариф мөрддөг эсэх, бүсээр ...	81
График 49. Үйл ажиллагаатай холбоотой бусад шалгуурыг хангаж байгаа эсэх, бүсээр	81
График 50. Сургалт-дасгалжуулалтын үйлчилгээ эрхлэх орчны стандартын шалгуурыг хангаж байгаа эсэх, бүсээр.....	81
График 51. Хүний нөөцийн мэргэжил, ур чадварын шалгуурыг хангаж байгаа эсэх, бүсээр	82
График 52. Сургалт-дасгалжуулалтын чанарын шалгуур хангаж байгаа эсэх, бүсээр	82
График 53. Спорт клубийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэхэд төрөөс ямар дэмжлэг шаардлагатай байна вэ?, бүсээр.....	82
График 54. Байнгын ажилтантай эсэх, бүсээр	84
График 55. Байнгын ажилтны тоо, бүсээр.....	84
График 56. Өнгөрсөн 2023 онд холбоо, клубээс тэмцээн зохион байгуулсан эсэх, бүсээр	85
График 57. 2023 оны орлогын мэдээлэл, клубын явуулж буй спортын төрлөөр, сая төгрөгөөр	85

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН НЭГ УДААГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛСАН ТУХАЙ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхээс харахад эрт үеэс уламжлагдан ирсэн тоглоом, наадам, үндэсний спорттой байдаг. Түүх судлаачдын тогтоосноор Монгол Улсын соёлын өвийн нэг болох үндэсний уламжлалт спорт, тоглоом, наадгай нь нэн эртний улбаатай бөгөөд одоогоор 2000 гаруй жилийн өмнөх цаг хугацаатай холбогдох археологийн дурсгал олдоод байна. Орчин цагийн спортыг Богд хаант Монгол Улсын Засгийн Газраас бага сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хөгжүүлж ирсэн нь баримтаар нотлогдсон бөгөөд эдүгээ зарим спортын төрлөөр олимп, паралимп, дифлимп, тусгай наадмуудад амжилттай оролцож, дэлхийн түвшинд өрсөлдөх хэмжээнд хөгжөөд байна.

Сүүлийн жилүүдэд спортын амжилт өндөр байгаатай холбоотойгоор иргэдийн спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, спортын клубийн тоо нэмэгдэж байна. Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж байгаа ч орон нутагт энэ төрлийн ажил үйлчилгээ эрхлэх нь бага байна.

Цаашид олон улсын жишгийн дагуу иргэдэд төрийн зүгээс үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, хувийн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. Үүний үр дүнд биеийн тамир, спортын салбар нь олон улсын жишгийн дагуу зах зээлийн харилцаан дээр хөгжиж, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагаар иргэдэд хүргэх ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж, төрийн оролцоог багасгах, төр бодлого, зохицуулалт, хяналтын үүрэгтэйгээр ажиллах тогтолцоог бүрдүүлэх юм.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

“Биеийн тамир, спортын тухай” хуулийн шинэчилсэн найруулгын 11 дугаар зүйлийн 11.1.14 дэх заалтад “Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлэх, хөтлөх, хэвийн ажиллагааг хангах, системийн өргөтгөл, шинэчлэлийг тогтмол хийх” гэж заасан болон ““Алсын хараа-2050” Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого”-ын Зорилт 3.5-ын I шат буюу 2021-2030 оны хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний 1-д заасан “Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ”, Статистикийн тухай Монгол Улсын хууль, ҮСХ-ны даргын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/186 дугаар тушаалаар баталсан аргачлалыг тус тус үндэслэн энэ удаагийн хоёрдугаар үзлэг тооллогыг зохион байгуулан явуулсан.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Улсын үзлэг, тооллого гэж тогтоосон хугацаанд тухайн улс оронд (буюу түүний нутаг дэвсгэрийн тодорхой хэсэгт) байгаа мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, олон нийтэд тархах цогц үйл ажиллагаа юм. Биеийн тамир, спортын нэг удаагийн анхдугаар улсын үзлэг тооллогыг 2017 онд зохион байгуулсан бөгөөд биеийн тамир, спортын төрийн байгууллага, түүний ажилтан болон спортын нийт барилга, байгууламж, биеийн тамир, спортоор хичээллэгч, спортын цол зэрэгтэй тамирчид зэргийг хамарч, тэдгээрийн талаарх мэдээллийг цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, үнэлэх, олон нийтэд тархах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Харин 2017 онд буюу

анхдугаар улсын үзлэг, тооллого зохион байгуулснаас 7 жилийн дараа хоёр дахь удаагаа улсын үзлэг, тооллого зохион байгууллаа.

Салбарын статистикийн суурь мэдээлэл болоод биеийн тамир, спортын чиглэлээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагын мэдээллийг бүрдүүлснээр нийтийн биеийн тамирын үйлчилгээг боловсронгуй болгох, үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилтын орчныг судлах, тэмцээн, наадмын тогтолцоог боловсронгуй болгох, биеийн тамир, спортын дэд бүтцийг сайжруулан нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой болох юм. Түүнчлэн, уг тооллогоор биеийн тамир, спортын барилга байгууламжийн байршлын мэдээллийн цахим сан үүсгэх боломж бүрдсэн.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Статистикийн мэдээлэл, тооллого, бүртгэл, судалгааны хамрах хүрээг үндэслэн, цаашид явуулах түүвэр судалгааны суурь мэдээлэлтэй болох;
- Үзлэг, тооллогод технологийн дэвшилттэй боломжийг нэвтрүүлэн, цаашид бага зардлаар тоо мэдээллээ тогтмол гаргах программ хангамжийг бий болгох;
- Тооллогын үр дүнгээр гаргах үзүүлэлт, хүснэгтийг боловсруулж, тэдгээрийн өөр хоорондын болон өмнөх үзлэг тооллоготой харьцуулах, уялдааг нягтлах, үр дүнгээ нийтийн хүртээл болгох;
- Салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг бий болгож, бүрэн биелүүллээ.

ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН НЭГЖ, ХАМРАХ ХҮРЭЭ

Биеийн тамир, спортын салбарт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэдийн эзэмшлийн спортын барилга, байгууламж болон биеийн тамир, спортоор чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг спортын клубийг хамруулсан.

ҮЗЛЭГ, ТООЛЛОГО ЯВУУЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ

- Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын газраас тухайн нутаг дэвсгэрт байх биеийн тамир, спортын чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг барилга байгууламж, биеийн тамир, спортоор чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллага, спортын клубийг тодруулан тухайн нэгжид тоологч тооллогын асуулгыг танилцуулан, асуултуудыг нэг бүрчлэн асууж тоолох;
- Үзлэг, тооллогын хугацаанд тооллогод хамрагдах нутаг дэвсгэрт нэгэн зэрэг тоолох;
- Үзлэг, тооллогын мэдээлэл нийтлэг, иж бүрэн байх;

ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үзлэг, тооллогын удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь Засгийн Газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын Улсын хороо, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодын тооллого зохион байгуулах зөвлөх багаас бүрдсэн тоологч, зөвлөх үйлчилгээний багийн төлөөлөгч нараас бүрдсэн ажлын хэсэг байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт тусгайлан бэлтгэгдсэн тоологч нар ажиллах бөгөөд тэдгээр нь биеийн тамир, спортын тооллогын бэлтгэлийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хангаж, тооллогыг удирдан зохион байгуулах бол тооллогын ажлын хэсэг, зөвлөх үндсэн багаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллана. Тухайлбал, бүхий л шатны биеийн тамир, спортын тооллогын нэгж бүрийг бүрэн хамруулах, тооллогын явцад хяналт, үнэлгээ хийх, шаардлагатай арга хэмжээ авах, үзлэг, тооллогын ажлыг дүгнэх, үр дүнг танилцуулах үүргийг хүлээж ажилласан.

Энэхүү үзлэг, тооллогын дүн мэдээлэл нь хоёр эх сурвалжаар гаргасан бөгөөд нэгдүгээрт төрийн байгууллага Монгол Улсын хэмжээнд үзлэг, тооллого хийж мэдээлэл цуглуулах, хоёрдугаарт спортын клубийн мэдээллийн санг нягталж, дахин боловсруулалт хийж, хоёр эх сурвалжийн мэдээлэлд тулгалт хийж зөрүүтэй байдлыг нягтлан шалгах, алдаатай мэдээллийг залруулах, үр дүнд салбарын хэмжээнд нэгдсэн бодит тоон үзүүлэлтийг гаргасан.

Мэдээлэл цуглуулах, тулгаж нягтлах, боловсруулалт хийх цахим программыг шинээр боловсруулан энэ удаагийн үзлэг тооллогод ашигласан бөгөөд тус программын хөгжүүлэлт хийгдэж захиргааны статистик мэдээллийг бүрэн цахимжуулах боломжтой. Энэ нь биеийн тамир, спортын мэдээллийн цахим сангийн суурь бааз болох юм.

Биеийн тамир, спортын салбар анх удаа орон даяар устгах спортын клубыг бүртгэн тоолж байгаа нь биеийн тамир, спортын салбарт шинэ эрх зүйн орчин бүрдэж, хөгжлийн шинэ бодлого хөтөлбөрийг боловсруулж байгаа цаг үетэй давхцаж байгаагаараа онцлогтой байлаа.

ТООЛЛОГЫН ТОВ, ХУГАЦАА

Биеийн тамир, спортын Улсын үзлэг, тооллогыг 2024 оны 09 сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд зохион байгуулан явуулсан.

ТООЛЛОГЫН АСУУЛГЫН МАЯГТ

Биеийн тамир, спортын Улсын нэг удаагийн үзлэг, тооллогын асуулгын маягыг Дорнод, Хэнтий, Булган аймгуудад туршсан бөгөөд туршилтаар гарсан санал, зөвлөмжийг тусган асуулгын маягтаа шинэчлэн боловсруулсан.

Биеийн тамир, спортын Улсын үзлэг, тооллогын мэдээллийг “спортын заалны асуулга”, “спортын гадаа талбайн асуулга”, “спортын клубын асуулга” гэсэн дэлгэрэнгүй 3 төрлийн маягтаар цуглуулсан болно. /ХАВСРАЛТ 3/.

ТООЛЛОГЫН АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ

Аливаа үзлэг, тооллогын ажил сайтар зохион байгуулалттай, чанартай явагдах эсэх нь тооллогын ажилтнуудын боловсрол, мэргэжлийн түвшнээс ихээхэн хамаардаг. Тооллогод оролцох бүх шатны ажилтан, тоологч шалгагч нарыг ойлголт, тодорхойлолт, аргачлал, заавар журмын талаар нэгдмэл нэг ойлголттой болгох үүднээс тооллогод ажиллах ахлагч, тоологч нарт сургалтыг танхимаар болон онлайн хэлбэрээр зохион байгуулсан.

Тооллогын мэдээллийн чанар нь тоологч нарын бүрэн мэдээлэл цуглуулалтаас ихээхэн шалтгаалах тул тоологч, шалгагчаар ажиллах хүмүүс нь биеийн тамир, спортын салбарын мэдлэг өндөр, ажилдаа нягт нямбай ханддаг, харилцааны өндөр соёлтой байхын зэрэгцээ тооллого эхлэхээс дуусах хүртэл тухайн сум, хооронд байнга суурьших хүмүүс байхаар ажилтнуудыг бүрдүүлэн ажилласан.

ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ, ГАЗРЫН ЗУРАГ

Үзлэг, тооллогын бүхий л үе шат бүрт газрын зураг ашигласнаар тооллогын мэдээллээр газарзүйн мэдээллийн сан үүсгэж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тогтолцоонд үндэслэн сэдэвчилсэн газрын зураг ашиглах боломж бүрдсэн.

Үзлэг, тооллогын мэдээлэл цуглуулалт дууссаны дараа мэдээллийг программд шивэх явцад тухайн нэгжийн байршлын цэгийг газар зүйн мэдээллийн системд оруулж тооллогын мэдээлэлтэй холбох байдлаар төлөвлөж ажилласан.

МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАЛТ

Мэдээлэл цуглуулалтыг Kobo toolbox программ хангамжийг ашиглан явууллаа. Мэдээллийн нууцлалыг хангаж мэдээллийн сан болон программ хангамжийг тус тусад нь сервер дээр байршуулсан. Мэдээлэл боловсруулалтад ArcGis, SPSS болон Microsoft office программ хангамжийг ашиглав. Тооллогод зориулан www.toollogo.sport.gov.mn вэб портал сайтыг шинээр хөгжүүлж мэдээллийг нэмж шивж оруулах, засварлах, хайлт хийх, үр дүнд боловсруулалт хийх зорилгоор excel форматаар татаж боломжтой байдлаар хөгжүүлж ашигласан.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ; СПОРТЫН ЗААЛ

МОНГОЛ УЛСЫН НИЙТ СПОРТЫН ЗААЛНЫ ТОО

1,541




Тогтмол

513

Улирлын чанартай

1,028



	УЛААНБААТАР	БАРУУН БҮС	ХАНГАЙН БҮС	ТӨВИЙН БҮС	ЗҮҮН БҮС
Тогтмол	378	43	24	63	5
Улирлын чанартай	321	164	231	226	86


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СПОРТЫН ЗААЛ

Биеийн тамир спортын салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх, спортын байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь хүн амын идэвхитэй хөдөлгөөн, спортоор хичээллэж, эрүүл амьдралын хэв маягт нөлөөлөн дундаж наслалтыг уртасгах, хөдөлмөрийн чадавхыг нэмэгдүүлэх зэрэг өргөн цар хүрээтэй нөлөөллийг бий болгодог. Энэ нь нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, ажлын байрыг бий болгох, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд залуучуудын хүсэл эрмэлзэл, ур чадварыг дээшлүүлэхэд мөн хувь нэмрээ оруулж байна. Ялангуяа бага насны хүүхдийг эрт спортоор хичээллүүлэх нь тэсвэр тэвчээр, тууштай байдал, багаар хамтран ажиллах зэрэг олон төрлийн зөв зан чанарыг суулган зөв хүн болон хүмүүжихээс гадна ирээдүйн шилдэг тамирчдыг бэлтгэх эхлэл болдог байна.

1.1. СПОРТ ЗААЛНЫ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Энэ удаагийн үзлэг, тооллогын хүрээнд Монгол Улсад нийт 1,541 спортын заал улсын хэмжээнд бүртгэгдсэн. Энэ нь 2017 оны анхдугаар тооллогын үр дүнтэй харьцуулахад 1.6 дахин өссөн буюу 556 спорт заал нэмэгдсэн байна. Үүний 54.6 хувь буюу 842 нь орон нутагт, 45.4 хувь буюу 699 нь Улаанбаатар хотод байдаг.


График 1. Спорт заалны тоон үзүүлэлт



Өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад спортын заалны тоо хэмжээ багагүй нэмэгдсэн нь сүүлийн жилүүдэд улсын төсвийн хөрөнгө оруулалт болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар спортын барилга байгууламж багагүй баригдаж ашиглалтад орж байгаагийн илэрхийлэл юм. Түүнчлэн анхдугаар тооллогын хүрээнд бэлтгэл сургалтын заалыг бүрэн хамруулаагүй зөвхөн спортын заал, спорт цогцолборыг тооллогод хамруулж байсантай мөн холбоотой болно.


Монгол Улсын эдийн засгийн 5 бүсээр нэгтгэн харахад баруун бүс 207, хангайн бүс 255, төвийн бүс 289, зүүн бүс 91, Улаанбаатар хотод 699 спорт заал тус тус бүртгэгджээ.

Зураг 1. Спорт заалны тоон үзүүлэлт, бүсээр



Монгол Улсын 21 аймгийн спорт заалны тоог, аймаг тус бүрээр доорх зургаар харуулсан ба орон нутгийн хувьд Хөвсгөл аймаг нийт заалны тоогоор тэргүүлж байна.

Зураг 2. Спорт заалны тоон үзүүлэлт, аймаг, нийслэлээр




Спорт заалны тоон үзүүлэлтийг 2017 онтой харьцуулан харахад баруун бүс 42 спорт заалаар, хангайн бүс 35 спорт заалаар, төвийн бүс 45 спорт заалаар, зүүн бүс 7 спорт заалаар тус тус өссөн дүнтэй байна. Улаанбаатар хотын хэмжээнд 699 спортын заал тоологдсон ба өмнөх тооллогын дүнгээс 427 заалаар нэмэгдсэн байна. Энэ нь Улаанбаатар хотын хэмжээнд хувийн хэвшлийн спортын байгууламж, бэлтгэл, сургалтын заал нэмэгдэж буйтай холбоотой.

Хүснэгт 1. Спорт заалны тоон үзүүлэлт, 2017 ба 2024 оны харьцуулсан байдлаар, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Төрийн	Орон нутгийн	Хувийн ААНБ- ЫН	Хувийн
Бүгд	1188	35	215	103
Баруун бүс	193	7	4	3
Баян-Өлгий	40	-	3	1
Говь-Алтай	30	-	-	-
Завхан	32	-	-	1
Увс	33	7	1	1
Ховд	58	-	-	-
Хангайн бүс	240	10	4	1
Архангай	32	-	1	-
Баянхонгор	42	3	1	-
Булган	34	-	-	-
Орхон	30	1	2	-
Өвөрхангай	40	-	-	1
Хөвсгөл	62	6	-	-
Төвийн бүс	268	4	10	7
Говьсүмбэр	9	-	1	-
Дархан-Уул	37	1	4	6
Дорноговь	40	1	1	1
Дундговь	35	-	-	-
Өмнөговь	47	1	3	-
Сэлэнгэ	49	1	1	-
Төв	51	-	-	-
Зүүн бүс	87	3	-	1
Сүхбаатар	21	1	-	-
Дорнод	32	-	-	1
Хэнтий	34	2	-	-
Улаанбаатар	400	11	197	91


Хоёр тооллогын хоорондох хугацаа буюу сүүлийн 7 жилд спорт заалны тоо хэмжээ Завхан, Орхон, Говьсүмбэр, Төв аймгуудаас бусад газруудад нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2024 оны тооллогын байдлаар Хөвсгөл, Ховд, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудад 50 болон түүнээс дээш тооны спорт заал ашиглагдаж байна. Харин Говьсүмбэр, Сүхбаатар, аймгуудад бусад аймгуудтай харьцуулахад бага тооны спорт заал тоологджээ.

Зураг 3. Спорт заалны тоон үзүүлэлт, 2017 ба 2024 оны харьцуулсан байдлаар



Үйл ажиллагаа явуулж буй нийт спорт заалыг хүн амын тоонд харьцуулсан байдлаар аймаг, сумын байршлаар дараах зурагт дэлгэрэнгүй харуулав.

Зураг 4. Улсын хэмжээнд байгаа нийт спорт заалны тоо




Хүснэгт 2. Спорт заалны үйл ажиллагааны явуулж буй хэлбэр, аймаг, нийслэлээр

Аймаг, Нийслэл	Бүгд	Тогтмол үйл ажиллагаатай		Улирлын чанартай үйл ажиллагаатай	
		п	%	п	%
Бүгд	1,541	513	33.3%	1,028	66.7%
Баруун бүс	207	43	20.8%	164	79.2%
Баян-Өлгий	44	8	18.2%	36	81.8%
Говь-Алтай	30	3	10.0%	27	90.0%
Завхан	33	5	15.2%	28	84.8%
Увс	42	5	11.9%	37	88.1%
Ховд	58	22	37.9%	36	62.1%
Хангайн бүс	255	24	9.4%	231	90.6%
Архангай	33	0	0.0%	33	100.0%
Баянхонгор	46	4	8.7%	42	91.3%
Булган	34	2	5.9%	32	94.1%
Орхон	33	0	0.0%	33	100.0%
Өвөрхангай	41	4	9.8%	37	90.2%
Хөвсгөл	68	14	20.6%	54	79.4%
Төвийн бүс	289	63	21.8%	226	78.2%
Говьсүмбэр	10	0	-	10	100.0%
Дархан-Уул	48	1	2.1%	47	97.9%
Дорноговь	43	28	65.1%	15	34.9%
Дундговь	35	8	22.9%	27	77.1%
Өмнөговь	51	15	29.4%	36	70.6%
Сэлэнгэ	51	7	13.7%	44	86.3%
Төв	51	4	7.8%	47	92.2%
Зүүн бүс	91	5	5.5%	86	94.5%
Дорнод	33	2	6.1%	31	93.9%
Сүхбаатар	22	1	4.5%	21	95.5%
Хэнтий	36	2	5.6%	34	94.4%
Улаанбаатар	699	378	54.1%	321	45.9%

Үйл ажиллагааны хувьд Улаанбаатар хотын 54.1 хувь буюу 378 заал, орон нутгийн 16.0 хувь буюу 707 заал тогтмол үйл ажиллагаа явуулдаг байна.

График 2. Спорт заалны ангилал




Монгол Улсын нийт спорт заалыг ангилан авч үзэхэд 81.4 хувь буюу 1,254 нь ердийн спортын заал, 11.2 хувь буюу 173 нь бэлтгэл сургалтын заал, 5.8 хувь буюу 90 нь спортын цогцолбор ордон бол үлдсэн 1.6 хувь буюу 24 усан бассейн байна

Хүснэгт 3. Спорт заалны ангилал, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Заалны ангилал			
	Спортын заал	Бэлтгэл сургалтын заал	Спорт цогцолбор	Усан бассейн
Бүгд	1,254	173	90	24
Баруун бүс	194	-	13	-
Баян-Өлгий	42	-	2	-
Говь-Алтай	27	-	3	-
Завхан	32	-	1	-
Увс	41	-	1	-
Ховд	52	-	6	-
Хангайн бүс	233	6	16	-
Архангай	31	-	2	-
Баянхонгор	45	1	-	-
Булган	29	2	3	-
Орхон	27	1	5	-
Өвөрхангай	37	2	2	-
Хөвсгөл	64	-	4	-
Төвийн бүс	253	17	18	1
Говьсүмбэр	7	3	-	-
Дархан-Уул	40	6	2	-
Дорноговь	38	1	4	-
Дундговь	33	2	-	-
Өмнөговь	43	4	4	-
Сэлэнгэ	42	1	7	1
Төв	50	-	1	-
Зүүн бүс	84	5	2	-
Дорнод	33	-	-	-
Сүхбаатар	20	1	1	-
Хэнтий	31	4	1	-
Улаанбаатар	490	145	41	23

Спорт заалны ангиллыг аймаг, нийслэлээр ангилан харахад ердийн спорт заалнаас бусад ангиллын дийлэнх нь буюу бэлтгэл сургалтын заалны 145 нь, спорт цогцолборын 41 нь, усан бассейны 23 нь Улаанбаатар хотод байршилтай байна. Энэ нь бусад спорт заалны төрлөөр орон нутгийг хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Зураг 5. Спорт заалны үйл ажиллагааны явуулж буй улирал, аймаг, нийслэлээр



Монгол орны цаг агаарын эрс тэс уур амьсгалтай холбоотойгоор спортын заалны үйл ажиллагаа зуны улиралд бүх бүс нутгуудад идэвхтэй байдаг байна. Харин өвлийн улиралд дунджаар 65.0 хувьтай байдаг ба хавар, намрын улирлуудад харьцангуй багасдаг байна.

Зураг 6. Спорт заалны үйл ажиллагааны зориулалт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ	965
ЗӨВХӨН БЭЛТГЭЛИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ЗААЛ, КЛУБ	120
СПОРТ ЦОГЦОЛБОР	107
ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ	96
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА	87
ХУВИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА	87
МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	31
БУСАД	48
НИЙТ	1,541

Монгол Улсын нийт спорт заалны 62.6 хувь буюу 965 нь ерөнхий боловсролын сургуулийн зориулалттай ба үлдсэн 37.4 хувь нь бусад төрлийн зориулалтаар ашиглагдаж байна. Үүний 7.8 хувь буюу 120 нь зөвхөн бэлтгэлийн зориулалттай, 6.9 хувь буюу 107 нь спортын төв, цогцолборууд, 6.2 хувь буюу 96 нь их, дээд сургуулийн зориулалттай бол 5.6

хувь буюу 87 нь тус тус төрийн захиргаа болон хувийн аж, ахуй нэгж байгууллагуудын зориулалтаар ашиглагдаж байна.

Хүснэгт 4. Спорт заалны үйл ажиллагааны зориулалт, үйл ажиллагааны хэлбэрээр

ЗОРИУЛАЛТ	Тогтмол үйл ажиллагаатай		Улирлын чанартай үйл ажиллагаатай	
	п	%	п	%
Ерөнхий боловсролын сургууль	258	26.7%	707	73.3%
Зөвхөн бэлтгэлийн зориулалттай заал, клуб	61	50.8%	59	49.2%
Спорт цогцолбор	56	52.3%	51	47.7%
Их дээд сургууль	36	37.5%	60	62.5%
Төрийн захиргааны байгууллага	22	25.3%	65	74.7%
Хувийн аж ахуйн нэгж, байгууллага	59	67.8%	28	32.2%
Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	5	16.1%	26	83.9%
Бусад	16	33.3%	32	66.67%

Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежууд спорт зааландаа улирлын чанартай үйл ажиллагаа явуулж буй нь сурагчдын амралтын үеэр спорт заалны хэрэглээ багасдагтай холбоотой. Үүнтэй холбоотойгоор сурагчдын амралтын үеэр заал, талбайг ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор хүүхэд, залуучуудын спортын дугуйлангийн тоог нэмэгдүүлэх, спортын арга хэмжээ зэргийг зохион байгуулах талд анхаарал хандуулах нь зүйтэй.

График 3. Спорт заалны өмчийн хэлбэр



Нийт спорт заалны 1,177 буюу 76.4 хувь нь төрийн өмчийн, 138 буюу 9.0 хувь нь Монгол Улсын хувийн ААНБ-ынх, 101 буюу 6.6 хувь нь Монгол Улсын хувийн иргэнийх, 48 буюу 3.1 хувь нь Гадаадтай улсын хувийн ААНБ-ынх, 31 буюу 2.0 хувь нь орон нутгийн өмчийнх байгаа бол үлдсэн 46 буюу 3.0 хувь нь бусад төрлийн өмчийн хэлбэртэй байна.

Хүснэгт 5. Спорт заалны өмчийн хэлбэр, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Төрийн	Орон нутгийн	Хувийн ААНБ-ын	Хувийн
Бүгд	1188	35	215	103
Баруун бүс	193	7	4	3
Баян-Өлгий	40	-	3	1
Говь-Алтай	30	-	-	-
Завхан	32	-	-	1
Увс	33	7	1	1
Ховд	58	-	-	-
Хангайн бүс	240	10	4	1
Архангай	32	-	1	-
Баянхонгор	42	3	1	-
Булган	34	-	-	-
Орхон	30	1	2	-
Өвөрхангай	40	-	-	1
Хөвсгөл	62	6	-	-
Төвийн бүс	268	4	10	7
Говьсүмбэр	9	-	1	-
Дархан-Уул	37	1	4	6
Дорноговь	40	1	1	1
Дундговь	35	-	-	-
Өмнөговь	47	1	3	-
Сэлэнгэ	49	1	1	-
Төв	51	-	-	-
Зүүн бүс	87	3	-	1
Сүхбаатар	21	1	-	-
Дорнод	32	-	-	1
Хэнтий	34	2	-	-
Улаанбаатар	400	11	197	91

Нийт тоологдсон спорт заалны 76.4 хувь нь Монгол Улсын төрийн өмчийн эзэмшлийнх байгаа бол 23.6 хувь нь бусад буюу хувийн өмчийн хэлбэрийн эзэмшилтэй байсан. Хувийн эзэмшлийн заал голчлон Улаанбаатар хотод төвлөрсөн байлаа.

График 4. Спорт заалны өмчийн хэлбэр, зориулалтаар






График 5. Спорт заалны ашиглалтад орсон он



Нийт ашиглалтад буй спорт заалнуудаас ашиглалтын жил хамгийн урт нь Ховд аймгийн Цэцэг сумын ЕБС-ын спорт заал 1924 онд ашиглалтад оржээ. Спорт заалны ашиглалтад орсон онуудыг авч үзвэл 2010-2019 онд 523 буюу хамгийн их тоогоор ашиглалтад орсон байна.

Зураг 7. Спорт заалны хэмжээ, бүс, нийслэлээр



МОНГОЛ УЛСЫН НИЙТ СПОРТ ЗААЛНЫ ЭЗЛЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ 4,558,351 м³

МОНГОЛ УЛСЫН НИЙТ СПОРТ ЗААЛНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ 592,016 м²

Харин спорт заалны талбайн хэмжээг аймаг тус бүрээр харьцуулан харвал Хөвсгөл аймаг, Ховд аймаг хамгийн их, Говьсүмбэр аймаг, Сүхбаатар аймаг хамгийн бага байна.


Хүснэгт 6. Спорт заалны хэмжээ аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Нийт эзлэхүүний хэмжээ, м3	Нийт талбайн хэмжээ, м2
Бүгд	4,558,351.00	592,016.00
Баруун бүс	561,612.00	73,834.00
Баян-Өлгий	103,664.00	14,609.00
Говь-Алтай	79,279.00	9,856.00
Завхан	72,896.00	9,389.00
Увс	103,106.00	14,297.00
Ховд	202,667.00	25,683.00
Хангайн бүс	747,298.00	92,846.00
Архангай	100,764.00	12,782.00
Баянхонгор	118,817.00	15,080.00
Булган	101,213.00	12,403.00
Орхон	115,174.00	13,572.00
Өвөрхангай	102,478.00	12,635.00
Хөвсгөл	208,852.00	26,374.00
Төвийн бүс	785,605.00	103,407.00
Говьсүмбэр	30,040.00	3,624.00
Дархан-Уул	136,758.00	16,733.00
Дорноговь	115,449.00	17,045.00
Дундговь	86,423.00	11,744.00
Өмнөговь	176,959.00	23,379.00
Сэлэнгэ	116,773.00	15,525.00
Төв	123,203.00	15,357.00
Зүүн бүс	238,696.00	29,546.00
Дорнод	102,211.00	12,119.00
Сүхбаатар	54,899.00	6,634.00
Хэнтий	81,586.00	10,793.00
Улаанбаатар	2,225,140.00	292,383.00

Нэг хүнд ногдох талбайн хэмжээ

Монгол Улсад биеийн тамир, спортоор зонхилон хичээллэдэг 6 – 64 насны нэг хүнд ногдох спорт заалны талбайн хэмжээ 0.176 м² байна.


Зураг 8. Нэг хүнд ноогдох заалны хэмжээ



Нэг хүнд ногдох спорт заалны талбайн хэмжээ Баруун бүсэд 0.178 м², Хангайн бүсэд 0.155 м², Төвийн бүсэд 0.202 м², Зүүн бүсэд 0.129 м², Улаанбаатар хотод 0.178 м² байгаа бол нэг хүнд ногдох талбайн хэмжээгээр Өмнөговь, Ховд аймгууд тэргүүлж байна.

1.2. СПОРТ ЗААЛНЫ ХИЙЦИЙН МАТЕРИАЛ

Зураг 9. Спорт заалны цахилгааны эх үүсвэр



Нийт спорт заалны 1514 буюу 98.2 хувь нь төвлөрсөн системээс, 8 буюу 0.5 хувь нь дизель станцаас, 7 буюу 0.5 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүрээс, 5 буюу 0.3 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөс тус тус цахилгаан эх үүсвэрээ авч байгаа бол 7 буюу 0.5 хувь нь цахилгааны эх үүсвэргүй байна.

Хүснэгт 7. Спорт заалны цахилгааны эх үүсвэр, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Тоосгон бүтэц	Угсармал бетон	Блок	Цутгамал төмөр бетон	Сэндвич хавтан	Чулуу, шавар	Модон	Тоосго, сэндвич хавтан хосолсон	Шилэн	Бусад
Бүгд	567	254	233	219	148	28	72	9	5	6
Баруун бүс	104	17	31	11	7	11	26	-	-	-
Баян-Өлгий	23	4	9	4	1	3	-	-	-	-
Говь-Алтай	14	4	2	-	2	5	3	-	-	-
Завхан	8	1	2	-	-	1	21	-	-	-
Увс	29	4	2	4	1	1	1	-	-	-
Ховд	30	4	16	3	3	1	1	-	-	-
Хангайн бүс	67	30	60	30	25	7	33	3	-	-
Архангай	1	9	21	2	-	-	-	-	-	-
Баянхонгор	13	1	13	5	8	2	3	1	-	-
Булган	10	-	9	10	3	2	-	-	-	-
Орхон	7	12	2	5	6	-	1	-	-	-
Өвөрхангай	20	3	10	2	3	3	-	-	-	-
Хөвсгөл	16	5	5	6	5	-	29	2	-	-
Төвийн бүс	158	24	39	20	38	5	5	-	-	-
Говьсүмбэр	6	-	1	1	2	-	-	-	-	-
Дархан-Уул	34	8	-	2	4	-	-	-	-	-
Дорноговь	23	3	10	3	3	-	1	-	-	-
Дундговь	16	-	6	2	7	4	-	-	-	-
Өмнөговь	19	5	7	7	12	1	-	-	-	-
Сэлэнгэ	36	2	5	3	3	-	2	-	-	-
Төв	24	6	10	2	7	-	2	-	-	-
Зүүн бүс	54	7	9	6	8	3	4	-	-	-
Дорнод	26	4	2	1	-	-	-	-	-	-
Сүхбаатар	10	2	3	1	5	1	-	-	-	-
Хэнтий	18	1	4	4	3	2	4	-	-	-
Улаанбаатар	184	176	94	152	70	2	4	6	5	6

Аймаг, нийслэл	Төвлөрсөн систем	Дизель станц	Бага оврын цахилгаан үүсгүүр	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	Цахилгаа-ны эх үүсвэргүй
Дархан-Уул	47	1	-	-	-
Дорноговь	43	-	-	-	-
Дундговь	35	-	-	-	-
Өмнөговь	51	-	-	-	-
Сэлэнгэ	51	-	-	-	-
Төв	51	-	-	-	-
Зүүн бүс	90	-	1	-	-
Дорнод	33	-	-	-	-
Сүхбаатар	22	-	-	-	-
Хэнтий	35	-	1	-	-
Улаанбаатар	687	3	3	2	4

Нийт спорт заалны цахилгааны эх үүсвэрийг аймаг, нийслэлээр харьцуулан харвал цахилгааны эх үүсвэргүй 7 заалны 3 нь баруун бүсийн аймагт 4 нь Улаанбаатар хотод байна. Мөн баруун бүсийн аймгуудад төвлөрсөн системээс бусад эх үүсвэрээс цахилгаан үүсвэрээ хангах байдал арай илүү байх хандлагатай байна.

Нийт спорт заалны 1,195 буюу 77.5 хувь нь төвлөрсөн системээс халаалтын эх үүсвэрээ авч байна.

Зураг 10. Спорт заалны халаалтын эх үүсвэр



Түүнчлэн спорт заалны халаалтын эх үүсвэрийг аймаг, нийслэлээр харьцуулан авч үзвэл Баруун бүсийн аймгууд хувийн болон ердийн галлагаагаар халаалтаа шийдэх явдал илүү түгээмэл байна.

Зураг 11. Спорт заалны ханын үндсэн хийц

Мод, банз	711
Спорт заалны зориулалтын хулдаас	358
Өнгөлсөн мод	136
Бетон/цемент	126
Модон паркет	111
Резин	36
Спорт заалны зориулалтын шал	23
Плита	18
Стандартын будагтай буюу лего шал	7
Бусад	15
БҮГД	1,541

Спорт заалны ханын үндсэн хийцийг авч үзвэл тоосгон бүтэц 567 буюу 36.8 хувь, угсармал бетон 254 буюу 16.5 хувь, блок 233 буюу 15.1 хувь, цутгамал төмөр бетон 219 буюу 14.2 хувь, сэндвич хавтан 148 буюу 9.6 хувь, модон ханатай 72 буюу 4.7 хувь, чулуу шавар ханатай 28 буюу 1.8 хувь, тоосон болон сэндвич хавтан хосолсон 9 буюу 0.6 хувь, шилэн ханатай 5 буюу 0.3 хувьтай байгаа бусад 6 буюу 0.4 хувийн заал нь өөр төрлийн материалын ханын хийцтэй байна.




Хүснэгт 8. Спорт заалны ханын үндсэн хийц, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Тоосгон бүтэц	Угсармал бетон	Блок	Цутгамал төмөр бетон	Сэндвич хавтан	Чулуу, шавар	Модон	Тоосго, сэндвич хавтан хосолсон	Шилэн	Бусад
Бүгд	567	254	233	219	148	28	72	9	5	6
Баруун бүс	104	17	31	11	7	11	26	-	-	-
Баян-Өлгий	23	4	9	4	1	3	-	-	-	-
Говь-Алтай	14	4	2	-	2	5	3	-	-	-
Завхан	8	1	2	-	-	1	21	-	-	-
Увс	29	4	2	4	1	1	1	-	-	-
Ховд	30	4	16	3	3	1	1	-	-	-
Хангайн бүс	67	30	60	30	25	7	33	3	-	-
Архангай	1	9	21	2	-	-	-	-	-	-
Баянхонгор	13	1	13	5	8	2	3	1	-	-
Булган	10	-	9	10	3	2	-	-	-	-
Орхон	7	12	2	5	6	-	1	-	-	-
Өвөрхангай	20	3	10	2	3	3	-	-	-	-
Хөвсгөл	16	5	5	6	5	-	29	2	-	-
Төвийн бүс	158	24	39	20	38	5	5	-	-	-
Говьсүмбэр	6	-	1	1	2	-	-	-	-	-
Дархан-Уул	34	8	-	2	4	-	-	-	-	-
Дорноговь	23	3	10	3	3	-	1	-	-	-
Дундговь	16	-	6	2	7	4	-	-	-	-
Өмнөговь	19	5	7	7	12	1	-	-	-	-
Сэлэнгэ	36	2	5	3	3	-	2	-	-	-
Төв	24	6	10	2	7	-	2	-	-	-
Зүүн бүс	54	7	9	6	8	3	4	-	-	-
Дорнод	26	4	2	1	-	-	-	-	-	-
Сүхбаатар	10	2	3	1	5	1	-	-	-	-
Хэнтий	18	1	4	4	3	2	4	-	-	-
Улаанбаатар	184	176	94	152	70	2	4	6	5	6

Аймаг, нийслэл	Тоосгон бүтэц	Угсармал бетон	Блок	Цугтамал төмөр бетон	Сэндвич хавтан	Чулуу, шавар	Модон	Тоосго, сэндвич хавтан хосолсон	Шилэн	Бусад
Бүгд	567	254	233	219	148	28	72	9	5	6
Төвийн бүс	158	24	39	20	38	5	5	-	-	-
Говьсүмбэр	6	-	1	1	2	-	-	-	-	-
Дархан-Уул	34	8	-	2	4	-	-	-	-	-
Дорноговь	23	3	10	3	3	-	1	-	-	-
Дундговь	16	-	6	2	7	4	-	-	-	-
Өмнөговь	19	5	7	7	12	1	-	-	-	-
Сэлэнгэ	36	2	5	3	3	-	2	-	-	-
Төв	24	6	10	2	7	-	2	-	-	-
Зүүн бүс	54	7	9	6	8	3	4	-	-	-
Дорнод	26	4	2	1	-	-	-	-	-	-
Сүхбаатар	10	2	3	1	5	1	-	-	-	-
Хэнтий	18	1	4	4	3	2	4	-	-	-
Улаанбаатар	184	176	94	152	70	2	4	6	5	6

Аймаг, нийслэл дэх спорт барилгын ханын үндсэн хийцийн хувьд Хангайн бүсэд тоосго болон блок хийц, Баруун, Төвийн, Зүүн бүсэд тоосгон бүтэц илүү давамгайлж байна.

Зураг 12. Спорт заалны шалны үндсэн хийц



Шалны үндсэн хийцийн хувьд модон шалтай 803 буюу 52.1 хувь, бетон шалтай 704 буюу 45.7 хувь, цементэн шалтай 22 буюу 1.4 хувь, резинин шалтай 11 буюу 0.7 хувьтай, блок шалтай 1 буюу 0.1 хувийн спорт заал байна.

Хүснэгт 9. Спорт заалны шалны үндсэн хийц, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	Модон	Бетон	Резинэн	Цемент	Блок
Бүгд	803	704	11	22	1
Баруун бүс	156	47	4	-	-
Баян-Өлгий	30	12	2	-	-
Говь-Алтай	23	6	1	-	-
Завхан	28	5	-	-	-
Увс	36	6	-	-	-
Ховд	39	18	1	-	-
Хангайн бүс	153	101	-	1	-
Архангай	26	7	-	-	-
Баянхонгор	25	21	-	-	-
Булган	12	22	-	-	-
Орхон	20	13	-	-	-
Өвөрхангай	29	12	-	-	-
Хөвсгөл	41	26	-	1	-
Төвийн бүс	165	123	1	-	-
Говьсүмбэр	7	3	-	-	-
Дархан-Уул	37	10	1	-	-
Дорноговь	13	30	-	-	-
Дундговь	22	13	-	-	-
Өмнөговь	25	26	-	-	-
Сэлэнгэ	27	24	-	-	-
Төв	34	17	-	-	-
Зүүн бүс	67	24	-	-	-
Дорнод	25	8	-	-	-
Сүхбаатар	16	6	-	-	-
Хэнтий	26	10	-	-	-
Улаанбаатар	262	409	6	21	1

Нийт спорт заалны шалны үндсэн хийцийг аймаг, нийслэлээр харьцуулан харахад аймаг орон нутагт модон болон бетон хийцийг ашиглах нь түгээмэл, харин Улаанбаатар хотод цемент, резин болон бусад төрлийн хийцийг ашиглах нь илүү ажиглагдаж байна.

Зураг 13. Спорт заалны шалны хучилтын материал

Мод, банз	711
Спорт заалны зориулалтын хулдаас	358
Өнгөлсөн мод	136
Бетон/цемент	126
Модон паркет	111
Резин	36
Спорт заалны зориулалтын шал	23
Плита	18
Стандартын будагтай буюу лего шал	7
Бусад	15
БҮГД	1,541

Манай орны спорт заалны шалны хучилтын материалын хувьд мод, банзан шалтай 711 буюу 46.1 хувь, спорт заалны зориулалтын хулдаастай 358 буюу 23.2 хувь, өнгөлсөн модтой 136 буюу 8.8 хувь, бетон/цементэн шалтай 126 буюу 8.2 хувь, модон паркетэн шалтай 111 буюу 7.2 хувь, резинин шалтай 36 буюу 2.3 хувьтай байна.

Хүснэгт 10. Спорт заалны шалны хучилтын материал, аймаг, нийслэлээр


Аймаг, нийслэл	Мод, банз	Зориулалтын хулдаас	Өнгөлсөн мод	Бетон/цемент	Модон паркет	Резин	Зориулалтын шал	Плита	Лего будаг	Бусад
Бүгд	711	358	136	126	111	36	23	18	7	15
Баруун бүс	167	21	13	3	3	-	-	-	-	-
Баян-Өлгий	35	5	4	-	-	-	-	-	-	-
Говь-Алтай	22	3	3	1	1	-	-	-	-	-
Завхан	30	1	1	-	1	-	-	-	-	-
Увс	33	4	3	2	-	-	-	-	-	-
Ховд	47	8	2	-	1	-	-	-	-	-
Хангайн бүс	147	42	9	42	7	6	2	-	-	-
Архангай	26	3	-	3	-	1	-	-	-	-
Баянхонгор	21	2	2	17	3	-	1	-	-	-
Булган	12	9	1	11	-	-	1	-	-	-
Орхон	21	4	1	4	1	2	-	-	-	-
Өвөрхангай	29	-	5	4	1	2	-	-	-	-
Хөвсгөл	38	24	-	3	2	1	-	-	-	-
Төвийн бүс	168	62	27	15	2	8	5	-	-	2
Говьсүмбэр	7	-	-	2	-	-	1	-	-	-
Дархан-Уул	34	7	2	1	-	-	4	-	-	-
Дорноговь	28	6	4	3	-	-	-	-	-	2
Дундговь	20	8	2	2	-	3	-	-	-	-
Өмнөговь	25	11	9	2	1	3	-	-	-	-
Сэлэнгэ	25	17	3	3	1	2	-	-	-	-
Төв	29	13	7	2	-	-	-	-	-	-
Зүүн бүс	59	16	7	5	2	2	-	-	-	-
Дорнод	24	4	1	3	-	1	-	-	-	-
Сүхбаатар	13	5	1	1	1	1	-	-	-	-
Хэнтий	22	7	5	1	1	-	-	-	-	-
Улаанбаатар	170	217	80	61	97	20	16	18	7	13

Эдгээр шалны хучилтын материалыг аймаг, нийслэлээр харьцуулан авч үзвэл аймгуудад мод банз, зориулалтын хулдаас ашиглах нь түгээмэл ба Хангайн бүсэд бетон, цементэн хучилт ашиглах нь бусад аймгуудыг бодвол түгээмэл байна. Харин Улаанбаатар хотод мод, банз, хулдааснаас бусад төрлийн хучилт ашиглах явдал орон нутгийг бодвол харьцангуй их байна.

1.3. СПОРТ ЗААЛНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Спорт заалны засвар, үйлчилгээний хувьд 921 буюу 59.8 хувь нь засвар, үйлчилгээ хийсэн бол 620 буюу 40.2 хувь нь засвар үйлчилгээ хийгдээгүй байна.

График 6. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал



Засвар, үйлчилгээний байдлыг аймаг нийслэлээр авч үзвэл нийт орон нутаг болон Улаанбаатар хотод ялгаагүй нийт заалны ихэнх буюу 50-с дээш хувьд нь засвар хийсэн хандлагатай байна.

Хүснэгт 11. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	ТИЙМ		ҮГҮЙ	
	n	%	n	%
Бүгд	921	-	620	-
Баруун бүс	125	60.4%	82	39.6%
Баян-Өлгий	27	61.4%	17	38.6%
Говь-Алтай	20	66.7%	10	33.3%
Завхан	22	66.7%	11	33.3%
Увс	19	45.2%	23	54.8%
Ховд	37	63.8%	21	36.2%
Хангайн бүс	146	57.3%	109	42.7%
Архангай	17	51.5%	16	48.5%
Баянхонгор	24	52.2%	22	47.8%
Булган	18	52.9%	16	47.1%
Орхон	21	63.6%	12	36.4%
Өвөрхангай	29	70.7%	12	29.3%
Хөвсгөл	37	54.4%	31	45.6%
Төвийн бүс	172	59.5%	117	40.5%
Говьсүмбэр	7	70.0%	3	30.0%
Дархан-Уул	39	81.3%	9	18.8%
Дорноговь	28	65.1%	15	34.9%
Дундговь	20	57.1%	15	42.9%
Өмнөговь	28	54.9%	23	45.1%
Сэлэнгэ	20	39.2%	31	60.8%
Төв	30	58.8%	21	41.2%
Зүүн бүс	56	61.5%	35	38.5%
Сүхбаатар	15	68.2%	7	31.8%
Дорнод	19	57.6%	14	42.4%
Хэнтий	22	61.1%	14	38.9%
Улаанбаатар	422	60.40	277	39.6%

Нийт спорт заалны засвар, үйлчилгээний байдлыг ашиглалтад орсон оноор авч үзвэл 2009 оноос өмнө ашиглалтад орсон заалнуудын дунджаар 74.7 хувьд нь засвар үйлчилгээ хийсэн байна.

Хүснэгт 12. Спорт заалны засвар, үйлчилгээний байдал, ашиглалтад орсон оноор

Ашиглалтад орсон он	ТИЙМ		ҮГҮЙ	
	n	%	n	%
1959 оноос өмнө	22	66.7%	11	33.3%
1960-1969 он	45	84.9%	8	15.1%
1970-1979 он	135	73.8%	48	26.2%
1980-1989 он	228	76.5%	70	23.5%
1990-1999 он	62	78.5%	17	21.5%
2000-2009 он	146	67.6%	70	32.4%
2010-2019 он	243	46.5%	280	53.5%
2020 оноос хойш	40	25.6%	116	74.4%

Засвар хийгдсэн он		n	%
ИХ ЗАСВАР	1999 оноос өмнө	3	0.5%
	2000-2009 он	42	6.9%
	2010-2019 он	448	73.6%
	2020 оноос хойш	116	19.0%
УРСГАЛ ЗАСВАР	1999 оноос өмнө	8	1.5%
	2000-2009 он	50	9.1%
	2010-2019 он	235	42.6%
	2020 оноос хойш	258	46.8%

